



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/528

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 1997 оны “Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай” 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Эрүүл мэндийн салбарын ажилчдын баярын өдрийг тохиолдуулан ард иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, эмнэлгийн тусламж үйлчилгээг хурдан шуурхай, чанартай хүргэх үйлсэд өөрийн хүч хөдөлмөр, сэтгэл оюунаа дайчлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Зэрэг сумын эрүүл мэндийн төвийн сантехникч Д.Жаргалсайхан, тогооч П.Түмэндэмбэрэл, вакцины сувилагч Д.Дончимэг, жолооч Д.Одонхүү, Мянгад сумын эрүүл мэндийн төвийн сувилагч Ц.Навчаа, вакцины сувилагч Д.Нямцэрэн, нярав М.Түвшинжаргал, эх баригч Б.Сэргэлэн болон аймгийн эрүүл мэндийн газрын гамшиг, яаралтай тусламж хариуцсан мэргэжилтэн О.Отгонжаргал, статистик бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинжаргал, мэдээлэл технологи, зайн оношилгоо хариуцсан мэргэжилтэн С.Намсрай, Мэдээлэл технологи, харилцаа холбооны ажилтны өдрийг тохиолдуулан Ховд аймгийн “Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаний ерөнхий нягтлан бодогч Д.Батцэнгэл, Дөргөн сумын ажилтан Б.Бадамгарав нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан албан хаагчдад 1 сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Зэрэг сумын Засаг дарга (Б.Батбилэг), Мянгад сумын Засаг дарга (М.Баатар), Эрүүл мэндийн газрын дарга

Zah A/528 Bo
8400 01 2702

-2-

(Ц.Мягмарсүрэн), Ховд аймгийн "Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаний дарга (Г.Ганжаргал)-д зөвшөөрсүгэй.



Б.ДҮГЭРЖАВ